# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 15 — Багахангай дүүрэг

| Д/д | Нийгмийн баталгааг хангах үзүүлэлт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт | Хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ажиллах таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд | Өрөө тасалгаа, танхимыг засварлан, ажиллах таатай орчин бүрдүүлэх | Засварласан өрөөний тоо | - | 1 | Албан хаагчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газар албан хаагчдын техник, тоног төхөөрөмж хэрэгсэлд 12.6 сая төг, Урсдал зардал-9.2 сая төг, дотоод албан томилолт-9.7 сая төг, 1 удаагийн тэтгэмж урамшуулал-15.0 сая төг, Бичиг хэргийн материал-11.5 сая төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэл зүйл-(өрөө тасалгааны чийдэн жижиг хэрэгслүүд) 7.8 сая төгрөгийг тус тус зарцуулав.<br>Албан хаагдын ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газрын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/63 дугаар тушаалаар хүүхэд асрах болон хөхүүлэхэд зориулан өрөө гарган засварлахад 4,1 сая төгрөгийг зарцуулав. | 90 | 90 |
| 2. | | Албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр аюулгүй | Компьютер техник төхөөрөмжийг засварласан тоо | - | 10 ба түүнээс дээш | ЗДТГ-ын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд 2-р хорооны ажлын албаны 6 принтерийг засварлан, 4 компьютерт программ суулгаж Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод сүлжээний гэмтлийг 2023 оны 05 сард засварлан, хэвийн ажиллагаанд оруулав. | 70 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллгааны дүрэм, журмыг чанд мөрдүүлж ажиллах | | | | ЗДТГ-ын 6 компьютер, 2-р хорооны 4, 1-р хорооны 6, нийт 16 компьютерыг форматласан бөгөөд техник хэрэгслийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллалаа.<br>Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/70 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газарт өнгөт принтер, скайнер, халаагуур тень, цаас устгагч 4,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулав. | | |
| 3. | Нийгмийн батлагааг хангах зорилтын хүрээнд | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, байгууллагын стратеги зорилтыг хангахад оруулсан хувь нэмэр, бүтээлч санал санаачлага, байгууллага, нийслэл, дүүргээс зохион байгуулагдсан аливаа арга хэмжээнд оролцсон оролцоо, ажлын цаг ашиглалт зэргийг харгалзан урамшуулал олгоно. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх албан хаагчдын тоо | - | 45 ба түүнээс доошгүй | Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг 1, 2, 3-р улирал, жилийн эцсээр байдлаар нэгтгэн тайлагнав. 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр Удирдлагын академийн багш профессор Л.Мөнхбаяр сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг зөв бодитой тодорхойлох талаар чиглэл өглөө. Сургалтад нийт 31 албан хаагч хамрагдлаа. Уг сургалтаар өгсөн чиглэлийн дагуу албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан батлууллаа. Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 46 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө, 4 албан хаагчтай хамтран ажиллах гэрээ байгуулав. ЗДТГ-ын албан хаагчдын 2023 оны 1, 2, 3-р улирал, жилийн эцсийн ажлыг үнэлэх ажлыг зохион байгуулав. Хагас болон жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түвшинг үнэлэх үнэлгээний багийг газрын даргын 2023 оны А/31, А/56 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, ЗДТГ-ын даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/67 дугаар тушаалаар 46 албан хаагч, Б/102 дугаар тушаалаар 45 албан хаагчийг Засгийн газрын 217 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын 98 дугаар тушаал, ЗГ-ын 2023 оны 442 дугаар тогтоолын 3 дахь заалтын дагуу 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Засаг даргын Тамгын газрын Б/121 дүгээр тушаалаар Тамгын газрын нэгжийн дарга нар болон албан хаагчдын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дүгнэн нийт 45 албан хаагчийг үнэлж урамшуулал олгов. | | |
| 4. | | Ажил, амралтын цаг, чөлөө авах, ээлжийн амралт, албан томилолт, цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмж, буцалтгүй тусламж, нөхөх олговор олгохтой холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомж, дотоод журмын хүрээнд зохион байгуулна. | Ээлжийн амралт, тэтгэмж урамшуулал олгох албан хаагчдын тоо | - | 100 ба түүнээс доошгүй | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын 1.2 дэх хэсэгт заасны дагуу “Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батлан Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны А/02 тушаалаар Албан хаагчдын Ээлжийн амралтын хуваарийг батлан гаргав. Ажилтан албан хаагчдын цагийг бүртгэж, цахим бүртгэл болон бүртгэлийн дэвтэр, сар бүрийн цагийн хоцролтын нэгтгэлийг үндэслэн цагийн баланс гарган, цалинг бодож сар бүр 2 удаа тогтоосон хугацаанд олгов.<br>Эрхэлсэн ажилдаа амжилт гарган тогтвор суурьшилтай ажилласан 1 | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагч төрийн дээд одон медалиар шагнуулсан тул хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу мөнгөн урамшуулал олгов.<br>Эрүүл мэндийн шалтгаанаар дүүрэгт хэвтэн эмчлүүлсэн 6 албан хаагч, хотод хэвтэн эмчлүүлсэн 2, мэргэжил дээшлүүлэн суралцсан 2 албан хаагч тус тус байна.<br>Нийт хуримтлалаас 860,000 төгрөгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн.<br>Байгууллагын тэтгэмж урамшууллын зардлаас ар гэрт нь гачигдал гарсан 2, Алдарт эхийн одон авсан 1 албан хаагчдад нийт 600,000 төгрөгийг өгч дэмжлэг үзүүлэв. Байгууллагын зардлаар сургалтад хамрагдсан 1 албан хаагчид 5 хоногийн цалинтай чөлөө олгон дэмжлэг, туслалцаа үзүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох шалгуур хангасан 7 албан хаагчийн мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/511 дүгээр захирамжаар зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна. Засаг даргын 2019 оны А/204 дүгээр захирамжийг үндэслэн 0-18 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдад хүүхдийн төрсөн өдрөөр 13 албан хаагчдад цалинтай чөлөө олгов. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 15-35 хувиар нэмэгдүүлэн олгож байна. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу 6 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулав. Төрийн албан хаагчдад ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр дүүрэгт шилжин ирж байгаа төрийн албан хаагчдыг дэмжин 15 орон сууцыг түрээслүүлэн 38 албан хаагчийг орон сууцаар хангасан.<br>Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, стандартыг орон нутгийн засаг захиргаанд хэрэглэх арга зүйн заавар ISO 18091:2020 стандартыг нэвтрүүлэхэд идэвхтэй оролцсон 10 албан хаагчдад 6,4 сая төг, Нийгмийн бодлогын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гарган ажилласан 1 албан хаагч албан тушаалын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэмцэх хэмжээний мөнгөн урамшууллыг Тамгын газрын даргын Б/118 дугаар тушаалаар олгов.<br>Санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачлага гарган 2020-2022 оны “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан тул 1 албан хаагч албан тушаалын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэмцэх хэмжээний мөнгөн урамшууллыг Тамгын газрын даргын Б/117 дугаар тушаалаар олгосон байна. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд “5 Ш” ажиллагааг дүүрэгт амжилттай хэрэгжүүлэн нийслэлийн дүүргүүд, агентлагуудын дунд зохион байгуулагдсан “Мэдье, Нэгдье” аянд нийслэлийн хэмжээнд гутгаар байрт шалгарсан амжилтыг үнэлэн 2 аалбан хаагчдад 2,0 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгов. Гэрт болон ердийн галлагаатай орон сууцад амьдардаг нийт 8 албан хаагчдад түлээ нүүрсний 1.6 сая төгрөгний дэмжлэг туслалцаа үзүүлэв.<br>Төрийн алба хаасан хугацааны | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдлийг Засаг даргын Тамгын газрын 35 албан хаагч, Хортой нөхцлийн нэмэгдлийг 4 албан хаагч, ажил хавсран ажилласан буюу хослон ажилласны нэмэгдлийг 10 албан хаагч, нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийг 2 албан хаагчдад тус тус олгов. | | |
| 5. | | Ахуйн зориулалтаар газар эзэмшиж, өрхийн аж ахуй эрхлэх, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад нь дэмжлэг үзүүлэх | Хүнсний ногоо тариалах албан хаагчийн тоо | - | 40 ба түүнээс доошгүй | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хаврын тариалалтад дэмжлэг үзүүлж 11 төрлийн ногооны үр 7 ААНБ, 40 иргэнд олгов. | 70 | 70 |
| 6. | | Албан хаагчийн ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, өдрийн хоолны мөнгөний хөнгөлөлт олгох, шаардлагатай тохиолдолд хэрэглээний үнийг түвшинг харгалзан тухай шинэчлэх | Хоол, унааны урамшуулал олгох албан хаагчийн тоо | - | 50 ба түүнээс доошгүй | Албан хаагчдад хоолны мөнгийг өдрийн 10000 төгрөгөөр тооцож, нийт 50 албан хаагчид 23,410,000 төгрөг, унааны зардлыг давхардсан тоогоор 6 албан хаагчид өдрийн 1000 төгрөгөөр тооцож 542.000 төгрөг олгоод байна. | 90 | 100 |
| 7. | | Гадаад дотоодын төрөл бүрийн аялал, туршлага судлуулах ажлыг дэмжиж ажиллана | Туршлага судлуулах албан хаагчийн тоо | - | 1 албан хаагчийг туршлага судлуулав. | БНХАУ, БНСУ, ОХУ, Нидерланд улсад ажиллан, эрүүл мэнд, спорт, үйлдвэрлэл, хог хаягдлын салбарын үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцон, мэдлэг ур чадвараа дээшлүүлэв. Үүнд:<br>1.Дүүргийн Засаг дарга Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин, Ханжөү, Жяшин, Наньнин, Чиньжөү, хотын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, туршлага судлах айлчлалыг 2023 оны 04 дүгээр сарын 20-28-ны өдрүүдэд хийв.<br>2.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Нидерландын Хаант улсын Гаагийн Академиас зохион | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан “Засаглалыг бэхжүүлэх нь” сэдэвт семинарт 2023 оны 08 дугаар сарын 07-16-ны өдрүүдэд хамрагдав.<br>3.“Багахангай үйлдвэр технологийн парк”-ийн захиргаа, инженерийн албаны 10 албан хаагч 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Шаньси Пиньяо Фэнгян Каол ба кокс группийн эрчим хүчний үйлдвэртэй танилцав. | | |
| 8. | Албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах зорилтын хүрээнд | Албан хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд үе шаттайгаар хамруулна | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах албан хаагчийн тоо | - | 30 ба түүнээс дээш | 2023 оны 05-12 дугаар сарын өдрүүдын хооронд Засаг даргын Тамгын газрын 32 албан хаагч эрт илрүүлэгт хамрагдав. | 70 | 70 |
| | | Албан хаагч гадаад улс оронд зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд дэмжлэг туслалцаа үзүүлнэ | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах албан хаагчийн тоо | - | - | Гадаад улс оронд зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай албан хаагч жилийн эцсийн байдлаар байхгүй болно. | | |
| 9. | Албан хаагчдын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах зорилтын хүрээнд | Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, амралт, соёл, урлаг, спорт, бялдаржуулах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлнэ | Арга хэмжээний тоо | - | 20 ба түүнээс дээш | “Бужиг” арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд 7 хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулж 12 ААНБ, өртөө, зөрлөгийн 1140 гаруй албан хаагч, иргэд оролцов.<br>“Багахангай марафон 2023” Насанд хүрэгчдийн УАШТ 2023оны 04-р сарын 30-ны өдөр Багахангай дүүрэгт болж өндөрлөлөө. Уг тэмцээнд 53 байгуулагын 500 гаруй тамирчид өрсөлдөж хурд хүч авхаалж самбаагаа сорин шилдэгүүдээ тодруулав.<br>Засаг даргын Тамгын газраас 3 албан хаагч амжилттай оролцлоо.<br>“Соёлын сэргэлт 2023” аяныг улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэг, 330 сум, 15 тосгонд 05 дугаар сараас эхэлсэн | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөгөөд дүүрэгт 2023.06.06-ны өдөр зохион байгууллаа. Үйл ажиллагаанд дүүргийн ИТХ-ын дарга Ф.Мөнхгэрэл, Засаг дарга А.Сүхболд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын Урлаг, уран бүтээлийн хэлтсийн дарга С.Дэлгэрмаа, Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга Э.Цэнд-Аюуш, Соёл, соёлын өвийн хэлтсийн дарга Г.Жанцансамбуу нар оролцов.<br>Албан хаагчдын бие бялдар чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хүрээнд долоо хоногийн мягмар гариг бүр заал авч албан хаагчдадаа хамруулав. Албан хаагчдын дунд волейбол, дартсын тэмцээнийг зохион байгуулан албан хаагчдын гэр бүлийн дунд волейболын тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулан нийт 39 хүүхдэд бэлэг өгөв. | | |
| 10. | | Цасны баяр, явган болон тойрон аяллыг зохион байгуулна | Арга хэмжээнд оролцсон албан хаагчийн тоо | - | 20 ба түүнээс дээш | "Багахангай 2023" өвлийн өдөрлөг арга хэмжээ 2023 оны 02 сарын 10-ны өдөр дүүргийн наадмын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний хаалтын үйл ажиллагаанд ИТХ-ын дарга Ф.Мөнхгэрэл, Засаг дарга А.Сүхболд, Засаг даргын орлогч Б.Болормаа, ИТХ-ын ажлын албаны дарга М.Даваанням Биеийн тамир, спортын хорооны дарга Г.Тэмүүлэн нар шагналыг гардуулж тэмцээнд оролцсон нийт тамирчдад ИТХ-ын дарга Ф.Мөнхгэрэл амжилт бүтээл, хамгийн сайн сайхан бүхнийг хүслээ.<br>Тус тэмцээнд 5 төрөлд 16 багийн 24 | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын 403 тамирчин оролцлоо. Засаг даргын Тамгын газраас 20 албан хаагч оролцон дараах байрыг эзлэв.Үүнд:<br>Байт харваа- Тэргүүн байр<br>Хийн буудлага- Гутгаар байр<br>Нийлбэр оноогоор- Гутгаар байр эзэлэн амжилт гаргалаа. | | |
| | ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | | | | | | 84% | 91% |

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОТГОНЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ЭРХ ЗҮЙ,
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН
МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХҮНИЙ НӨӨЦ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ,
ШАГНАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ЗОЛЗАЯА